

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**МАОГИЙНХНААС БНМАУ-ЫН ТҮҮХИЙГ ХЭРХЭН
ГУЙВУУЛЖ БАЙГААГ ШҮҮМЖЛЭХ НЬ***

**Ш. Бира
Н. Ишжамц
Ш. Сандаг**

Бээжингийн эрх баригчид сүүлийн үед америкийн империализм ба бусад харгис хүчинтэй улам ойртон сүлбээлдэж намжмал үйл явцыг тасалдуулах, олон улсын байдлыг хурцатгах, хүн төрөлхтнийг «хүйтэн дайны» үед буцаан оруулах, зэвсгээр хөөцөлдөх явдлыг улам хүчтэй болгох, дэлхийн шинэ дайн өдөөн хатгах аюултай бодлогоо урьд урьдынхаас илүү даамжруулж байна. Эдгээр харгис хүчин дэлхий дээр жанжлалаа тогтоохын тулд Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба социалист бусад орнуудыг дайран давшлах, гүжирдэн гүтгэх хорт явууллагаа «зөвлөлтийн аюул», «коммунизмын аюул» гэгч огт хоосон үг яриа, шуугиан дэгдээх аргаар халхлан идэвхжүүлж байгаа нь нийтэд тодорхой билээ. Энэ тухай МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга нөхөр Ю. Цэдэнбал хэлсэн нь: «Хятадын одоогийн эрх баригчид олон улсын империалист хүчинтэй нэгэн эгнээнд явж байна. Эдийн засаг, улс төрийн талаар шахан хавчиж, бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс бүдүүлгээр оролцож, цэрэг дайны аюул занал бий болгон хөрш улсуудын эсрэг зэвсэгт халдлага үйлдэж, шинэ колоничлолыг өөгшүүлэн хөхүүлж, фашист болон арьс өнгөөр ялгаварлагч дэглэмүүдийг дэмжиж байгаа энэ бүхэн нь бээжингийн эрх баригчдын бодлогын салшгүй шинж чанар боллоо. Иймээс манай нам империализм, харгис хүчнийг эсэргүүцсэн тэмцлийг хятадын эрх баригчдын их гүрний жанжлах үзлийг эсэргүүцсэн тэмцэлтэй шууд холбон үзэж байна. Бид ард түмний эсрэг, социализмын эсрэг хятадын эрх баригч бүлгийнхний чиг бодлогыг хойшид ч шийдвэртэй илчилж, бүх нийтийн энх тайванд улам бүр аюул учруулж байгаа тэдний их гүрний жанжлах, эзэрхийлэн түрэмгийлэх ажил явууллагын эсрэг эвлэршгүй тэмцэх болно»¹ гэжээ.

ЗХУКН-ын XXVI их хурал орчин үед маоизмын «онол», практикийн харгис чанарыг дэлхий нийтийн өмнө илчлэн харуулах явдал урьд урьдынхаас улам чухал болж байгааг онцлон заасан билээ.

Одоогийн бээжингийн эрх баригчид дэлхий дээр жанжлалаа тогтоохын тулд өөрсдийн баримталж буй аюултай чиг бодлогоо хэрэгжүүлэхээр махран оролдхийлж, аль эртээс уламжлан ирсэн «хятад төвийн» үзлийг сэргээн дэвэргэж байна. Мөн тэд БНХАУ-ын хил хязгаарыг Монгол, Манжийн эзэн хаадаас Хятадыг оролцуулан харь бусад олон орныг байлдан дагуулж байгуулсан эзэнт гүрний асар их газар нутгийн хэмжээнд хүртэл тэлэхийг санаархан, түүнээ түүхийн үүднээс зөвтгөхийн тулд дэлхий нийтийн түүх, ялангуяа хөрш улс орны түүхийг янз бүрээр мушгин гуйвуулж байна.

*Уг бүтээл. 1980 онд Улаанбаатарт орос англи хэлээр хэвлэгдсэн бөгөөд монгол эхийн товч нь тус сэтгүүлд анх удаа нийтлэгдэж байна. (ред)

¹Ю. Цэдэнбал МАХН-ын XVIII их хурал дээр тавьсан Намын Төв Хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт. «Үнэн» 1981 оны V сар. 27.

Маогийнхан их гүрний дээрэнгүй, жанжлах санаархал гарган айл хөрш улс орнуудын нутаг дэвсгэрт байнга өнгөлзөж байдаг ажил явууллага нь эхлээд түүхийн аль нэг үед байгуулагдсан хил хязгаарын гэрээ хэлэлцээрүүдийг бүдүүлгээр завхруулан гуйвуулдаг байна. Тэд БНХАУ-ын газрын зураг дээр бусдын газар шороог Хятадын харъяанд оруулан зурж булаалдах, дараа нь хилийн будлиан өдөөн хатгах, эцэст нь бүр зэвсэглэн дайран довтолохоос ч буцахгүй байна.

Хятадын эрх баригчид 1959, 1962 онд Энэтхэгийн эсрэг, 1969 онд ЗХУ-ын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдэж, мөн 1979 онд социалист Вьетнамын эсрэг хагас сая цэргийн хүчээр түрэмгий дайн хийж дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлж байв.

Одоогийн хятадын эрх баригчдаас социализмын эсрэг явуулж буй харгис дээрэнгүй бодлогонд нь БНМАУ урьдын адил чухал суурь эзэлсээр байна. Хятадын эрх баригчид БНМАУ-тай залгасан 5000 орчим км үргэлжилсэн хил хязгаарын дагуу цэрэг дайны бэлтгэл шаргуу явуулж, тус улсыг түрэмгийлэн эзлэх хорт төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг зүйл бүрээр оролдсоор байна.

Нөхөр Ю. Цэдэнбал бичихдээ, «олон улсын тавцан дээр хятадын маоист удирдах бүлгийн явуулж буй социализмын эсрэг түрэмгийлэн эзлэх илэрхий чиг бодлогын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд онцлог илрэл бол бүрэн эрхт тусгаар тогтносон БНМАУ-ын талаар баримталж байгаа бодлого юм. Хятадын удирдагчдаас Монголын эсрэг явуулж байгаа бодлого бол монголын ард түмнийг, түүний эрх чөлөөт, тусгаар тогтносон хөгжлийг, манай ард түмний хамгийн яруу сайхан ололт ЗХУ-тай тогтоосон ах дүүгийн эвдэршгүй найрамдлыг туйлаас үзэн ядах үзлийг нэвт шингээсэн хамгийн бузар булай бодлого мөн гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Хятадын милитаристууд, Чан Кайшийнхнаас уламжлан ирсэн их гүрний колоничлох өнгөлзлөг нь БНМАУ-ын талаар хятадын удирдагчдын баримталдаг бодлого, явууллагын үндэс болж байна»² гэжээ.

Маогийнхны үзэл суртлын хорлон сүйтгэх ажил явууллага, эзэрхэг түрэмгий бодлогонд нь түүхийг мушгин гуйвуулах явдал чухал байр эзэлж байгаа бөгөөд энэ нь одоо Хятадад маогийнхны их гүрний дээрэнгүй, жанжлах бодлогын эрх ашигт бүрэн дүүрэн үйлчилж байна. Түүхэнд урьд өмнө гарч агсан «эрэлхэг баатруудын» улс төрийн элдэв адал балмад явдлыг зөвтгөх, шагшин магтах, өөрсдийнхөө улс төрийн бодлогод тохируулан түүхийн үнэнийг дур мэдэн гуйвуулах явдал одоогийн Хятадад эрээ цээрээ алдсаныг олж харахад төдий л бэрх биш байна. Энэ бүгдийг сайтар тунгаан мэдэхийн тулд маогийнхнаас БНМАУ-ын түүхийн гол зангилгаа асуудлуудыг хэрхэн гүтгэн гуйвуулж байгааг жишээ болгон авч үзье.

Маогийнхан их гүрний дээрэнгүй, жанжлах, эзэрхийлэн түрэмгийлэх алсын хорон санаат бодлогондоо захируулан манай монголын ард түмний түүх, одоогийн социалист байгуулалтын ололт амжилтыг гүтгэн гуйвуулах ажил явууллагаа хүчтэй болгож байна. Зарим баримт дурдвал:

1949 онд Шанхайд хэвлэсэн «Хятадын шинэхэн газрын зураг», 1954 онд Бээжинд хэвлэсэн «Орчин үеийн хятадын товч түүх», 1962 онд хятадын түүх судлалын сэтгүүл «Лиши яньзю»-д «Чингэс хааны тухай» түүхчин Хань Жулиний бичсэн өгүүлэл, 1972 онд Бээжинд гарсан «Дэлхийн газрын зураг», Ши Да хэмжээгчийн зохиож 1976 онд Бээжинд нийтэлсэн «Хятадын эсрэг хаант Оросын явуулсан түрэмгийлэл», Го Можогийн 1977 онд редакторлаж Бээжинд гаргасан «Хятадын түүхийн найруулал», 1977 онд Хөх хотод хэвлэсэн «Монгол угсаатны товч түүх», 1979 онд «Гуанмин жибао» сонинд Цю Шушэний нийтэлсэн «Чингэс

²Ю. Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал. УБ., 1976. 654 дүгээр тал.

хааныг үнэлэх тухай хэдэн асуудал» өгүүлэл, 1979 онд Хөх хотод хэвлэсэн «Хятадын умард зүгийн эртний үндэстнүүдийн товч түүх» гэх зэрэг ном, өгүүлэл, газрын зургуудад манай монголын ард түмний түүхийн зангилгаа асуудлуудыг гуйвуулж, Монгол орныг бүхлээр буюу ууган газар нутгийг нь тасчин Хятадын хэсэг болгон монгол хаадыг Хятадын хаад байсан мэтээр түүхийг гуйвуулан бичжээ.

Үүний зэрэгцээгээр Монголын түүхийг «судлах» нэрийдлээр Хятад дахь монгол судлалын мэргэжилтэн, түүхчдийн хүчийг нэгтгэх, янз бүрийн нийгэмлэг шинээр байгуулах буюу хуучин байсныг сэргээн ажиллагааг нь идэвхжүүлэх арга хэмжээ авах боллоо. Жишээлбэл: Монголын түүх судлах бүх хятадын нийгэмлэгийн ээлжит чуулган 1980 оны долдугаар сард Хайларт болж, Хятадын өнцөг булан бүхнээс монголын түүх, одоогийн байдлыг судлагчид цугларч «судалгаагаа» зохицуулах асуудал хэлэлцжээ. Мөн 1980 оны аравдугаар сард Нанжин хотноо Юан гүрний түүх судлах нийгэмлэг байгуулсан байна.

1. Хятад төвийн үзэл ба Монголын эртний түүх

Сүүлийн үед марксист зохиолуудад маоизмын үзэл-улс төрийн эх сурвалжийг илчлэн шүүмжлэх талаар их анхаарал тавьж байгаа нь зүй ёсны хэрэг. Тухайлбал, Хятадад элдэв янзын харгис этгээд, үндсэрхэг үзэлтнүүдэд их хан үндэстний дээрэнгүй үзэл номлоход олон зуун жилийн турш онолын үндэс нь болж байсан Күнзийн хятад төвийн үзэл гэгч маоизмд их нөлөө үзүүлсэн ажээ.

Маоист түүхчид хятад төвийн үзлийг ашиглаж хүн төрөлхтний түүхэнд, ялангуяа Азийн ард түмний түүхэнд хятадын байр суурийг хэтэрхий өргөн дөвийлгэхийн хамт бусад ард түмний, юуны түрүүнд айл хөрш, бага жижиг ард түмний өвөрмөц түүхийг басамжлан доромжилж байна. Хуучин, шинэ үеийн хятадын эзэн хаадын дээрэнгүй, жанжлах санаархалд ямагт үйлчилж ирсэн хятад төвийн үзэл бол улс түмний, түүний дотор Монголын ард түмний эртний түүхийг маочлан гуйвуулах явдлын үндэс болж байна.

Хятад төвийн тухай гол үзэл өнгөрсөн түүхийн эрт дээр цагт, Шан Инь угсааны хаадын үед (манай тооллын өмнөх XVII-XI зуун) Хятад ба түүнтэй айл хөрш, хятад бус олон ард түмний хооронд үүсэн тогтнож байсан туйлын нарийн төвөгтэй, заримдаа ч маш хурц ширүүн харилцааны явцад анх эхлэн бий болсон ажээ. Энэ үзлээр ахул, Инь угсааны эзэн хаад ард түмнийг тэнгэр бурхны таалалаар захиран жолооддог байсан ажээ. Жоу угсааныхны хаанчлалын үед (манай тооллын өмнөх XI-III зуун) Хятадын эзэн хааныг «Тяньзы» («Тэнгэрийн хөвүүн») гэж өргөмжилж, түүнийг тэнгэрийн тааллаар Тэнгэрийн доорхи орчлон дэлхийг удирдан жолоодох ёстой гэж үзэж байжээ. Хятадын ноёрхогч ангийнхны ойлголтоор бол «Тэнгэрийн хөвүүн» нь зөвхөн Хятадын өөрийн нь нутаг дэвсгэр төдийгүй, бас айл зэргэлдээх, хятад бус олон ард түмний газар шорооны дээд эзэн байх ёстой ажээ. Тэд тэнгэрийн доорхи орчлонгийн төв бол «Жунго» («Дундад улс») өөрөөр хэлбэл Хятад мөн гэж үзэж байжээ.

Хятад төвийн үзэл нь эртний Хятадын улс төр, ёс суртахуун ба шашны гол номлол болох Күнзийн сургаалд үндэслэсэн бүхэл бүтэн ойлголт мөн. Күнзийн сургаал ёсоор бол хааны засаг засал нь бүх дэлхий ертөнцийг хамарсан, эмхтгэн тохинуулах хүчин мөн бөгөөд Хятадын эзэнт гүрний хил хязгаарын чанад орших улс орон бүхэн бол эмх журамтай ертөнцийн гадна үлдэж эмх замбараагүй байдалд байх ажээ. Эмх замбараагүй байдал «бүдүүлгүүдийн» гол шинж байдаг. Учир нь тэд ертөнцийг цэгцлэн тохинуулагч дээдийн хүчинтэй биеэ даан харил-

цаж чадахгүй ажээ. Эмх замбараагүй байдал бол зан суртахууны бүх хэм хэмжээг бүрэн зөрчин эвдэхийг хэлнэ. Хүн бол юуны өмнө зан суртахуунтай амьтан мөний тул, «гадна талын газар нутагт» оршин суугч бухэн бол үгийн үнэнхүү утгаар хүн гэж тооцогдох ёсгүй гэнэ. «Бүдүүлгүүд» гэгч нь харахад хүн царайтай боловч, оюун ухаан, уг чанараараа араатан мөн бөгөөд төрөлхийн энэ чанар нь тэдгээрийг дээрэм хийхэд түлхэнэ. Тэд (бүдүүлгүүд) бол Хятадад гай гамшиг таригчид мөн⁴ гэж үзэж байжээ.

Маогийнхны ихэд өргөн хэрэглэж байгаа «Дундад улс» (Жунго), «Дундад улсын үндэстэн» (Жунхуа Миньзу), «Олон үндэстнээс бүрэлдсэн, нэгдмэл Хятад улс» гэх мэт ойлголт нь Хятад төвийн үзлийн гол агуулгатай нягт холбоотой. Эдгээр ойлголт бол хятад төвийн үзэл санааны урсгал нөлөө маоизм ба хятадын маоист түүх судлалд нөлөөлсний шууд үр дагавар мөн.

Одоогийн хятад түүхчид нь урьдын феодал түүхчид, гоминданы үзэл сурталчдын хойноос орж түүхэн ёсны зарчим, түүхийн бодит байдалд диалектикийн үүднээс хандах ёсыг бүдүүлгээр зөрчиж, зарим нэг тасархай баримт сэлт, түүхийн жишээг дур мэдэн гуйвуулан тайлбарлах замаар Хятад улс бол аль эртнээс хятадууд ба Төв Азийн ард түмний арьс өнгө-угсаатны нийтлэг шинжид үндэслэсэн бөгөөд хуваагдашгүй нэг их үндэстний эх орон мөн гэдэг санааг түүхчилэн батлахыг бүхий л аргаар оролдож байгаа юм. Үндэстэн бол капитализмын үед гарч ирсэн тодорхой түүхэн ойлголт мөн болох нь хүн бүхэнд ойлгомжтой билээ. Маогийнхны нотлож байгаагаар «үндэстэн» гэгч нэг мөнхийн ойлголтоор хий хоосон хөөцөлдөх шиг тийм метафизик зүйл хаана байх билээ! Хэрэв «жунхуа-миньзу» гэгч нэр томъёоны дор түүхийн явцад үнэхээр бүрэлдэн тогтносон хүмүүсийн нийтлэгийг хэлж байгаа юм гэж бодоход социалист үйлдвэрлэлийн харилцаа эвдрэн бусниж цэрэг-хүнд суртлын диктатур ноёрхож хөгжилд нь ухралтын хүчтэй процесс явагдаж байгаа одоогийн Хятадын нөхцөлд энэ түүхэн шинэ үзэгдлийн тухай ярихад үнэхээр эрт бөгөөд ерөөс ярихын ч аргагүй зүйл болох нь мэдээжийн хэрэг юм. «Нэг нэгдмэл улс үндэстэн» гэдэг томъёо нь ч шинжлэх ухааны үндэсгүй бөгөөд шинжлэх ухааны үүднээс үзэхэд мөн л худал хуурамч бас нэг өөр ойлголтыг «онолын» үндэстэй болгоход зориулагджээ. Тэр ойлголтоор бол Хятад нь түүхийнхээ туршид олон үндэстний нэгдмэл нэг улс болон тогтносоор ирсэн учир одоо Хятад бол айл хөрш бараг бүх улс түмнийг гарал үүсэл, түүхэн хувь заяа, улсын хил хязгаар, одоо байгаа бодит байдлыг нь ч үл харгалзан өөртөө нэгтгэн авах дархан эрхтэй болж байгаа ажээ.

«Жунхуа миньзу» гэгч ойлголт бол Хятадын доторхи хятад бус олон жижиг үндэстний талаар явуулж байгаа их гүрний дээрэнгүй бодлогоо халхавчлан нуухад нь маогийнханд тус болох ёстой болно. Гзвч тэдгээр улс үндэстэн нь тусгаар тогтнох эрх байтугай үндэсний ба нийгмийн хөгжлийн хамгийн наад захын эрх чөлөөгүй болж үндэс угсаа, соёлын хувьд уусан үгүй болох аюул заналд учраад байгаа нь тодорхой билээ. Мао Зэдун ба түүний талынхан Хятадад үндэсний асуудлыг дур мэдэн «шийдвэрлэсэн» нь үндэсний асуудлын тухай марксист-ленинист сургаалын шууд эсрэг зүйл болжээ. Хятадын эрх баригчид тус улсын доторхи хятад бус ард түмэнд биеэ даах эрх олгохыг татгалзсанаар үндэсний асуудлын талаарх марксизм-ленинизмын гол зарчмыг таягдан хаясан хэрэг болов.

⁴Материалы по истории Тибета при династии Мин. 1959 (хятад хэлээр) 204 дүгээр тал. А. С. Мартыновагаас иш татав,—«Народы Азии и Африки», 1972, № 5. 78 дугаар тал

«Жунхуа миньзу» гэдэг ойлголт нь мөн түүнээс урган гарч буй «олон үндэстний нэгдмэл нэг Хятад улс» гэдэг нэр томъёоны хамтаар тун алсын хол эчнээ санааг агуулжээ. Эдгээр ойлголт нь одоогийн Хятадын удирдлагын явуулж буй эзэрхэг түрэмгий жанжлах гадаад бодлогыг «түүхийн» үүднээс зөвтгөн бататгах зорилготой юм. Маогийн түүхчид чухамдаа шинжлэх ухааны эсрэг энэ мэт тодорхойлолт, нэр томъёонд тулгуурлан өөрийн удирдлагын зүгээс БНМАУ, ЗХУ, БНСВУ, Кампучи, Лаос, Солонгос, Бирма, Балба, Энэтхэг зэрэг айл хөрш улсуудын газар дэвсгэрт улайран шунахайрч, булаан эзлэх бодлого явуулж байгааг нь аль болохоор зөвтгөхийг оролдож байна.

Энэ мэт үзэл онолоо Бээжин улс төрийн үйл ажиллагаандаа шууд ашиглаж байгаа нь нууц биш билээ. БНХАУ-ын Гадаад явдлын яамны 1969 оны аравдугаар сарын 9-ний нэг албан баримт бичигт өгүүлсэн нь: «Аль хоёр мянга гаруй жилийн тэртээ Хятад бол олон үндэстний феодалын нэгдмэл нэг улс болсон билээ. Хятад нь феодалын янз бүрийн угсааны хаанчлал бие биеэ халж, аль ямар ястан засгийн эрхэнд орж байснаас шалтгаалахгүйгээр хэзээ ямагт олон үндэстний нэгдмэл нэг улс байлаа ...Манай тооллын өмнөх IV зууны үед Их Хэрэм хэсэг хэсгээр байгуулагдаж улмаар манай тооллын өмнөх III зуунд Цинь улсын үед хоорондоо холбогдсон билээ. Гэвч тэр үед ч гэсэн Их Хэрэм Хятадын хил хязгаар болж байгаагүй юм»⁵ гэжээ.

Энэ ишлэлээс үзвэл маогийнхан хятад төвийн үзлээ баримтлан одоо ч гэсэн эргэн тойрон байгаа бүх «бүдүүлгүүдийг» нэгтгэсэн нэг ёсны «Тэнгэрийн их хаант улс» («Тянься») маягийг их Хятад улсыг байгуулахыг санаархан чармайж байгаа нь илэрхий байгаа юм.

«Дөрвөн дээрэмчний бүлгийг» шүүмжлэх явцад Хятадын түүхчид үзтэл илэрхий алдаатай, ямарч утга учиргүй зарим нэг баримтлалаасаа буцахад арга буюу хүрч байгаа боловч тэд Хятад дахь үндэстний цөөнх ба айл хөрш ард түмний түүхийн талаар баримталдаг их гүрний дээрэнгүй үзэл бодлоосоо ангижрахыг огтхон ч хүсэхгүй байна. Тэд умард зүгийн ард түмний эсрэг Хятадын эзэн хаадаас явуулж байсан булаан эзлэх аян дайн эзэрхэг түрэмгий бодлогыг урьдын адил «шудрага», «дэвшилттэй» үйл явдал мөн гэж үзсээр байна. Жишээ нь Чэнь Шижи гэгч нэг зохиогч огтхон ч санаа зоволгүй бичсэн нь: «Үндэстний цөөнхийн толгойлогчдын үргэлж өдөөсөөр ирсэн халдлага довтолгооны эсрэг Хятад өөрийгөө батлан хамгаалах буюу тэдний эсрэг гэсгээн цээрлүүлэх аян дайныг хийдэг байсан нь төв дундын тэгш талын (Хятадын гэж унш-ред) соёл, эдийн засгийг хамгаалан хурдан хөгжүүлэхэд чиглэсэн ямагт шударга шинж чанарыг агуулж байсан нь эргэлзээгүй»⁶ гэжээ. Одоогийн хятадын түүхчдийн өгүүлж байгаагаар нэг талаас хан хятад, нөгөө талаас хан бус, умардын улс түмний хооронд олон зуун жилийн турш болж байсан бүх дайн дажин нь зөвхөн нэг улсын доторхи ястнуудын хоорондох хямрал мөргөлдөөн төдий байсан буюу өөрөөр хэлбэл, Хятадын дотоод хэрэгт хамаарах үйл явдал төдий байсан юм гэнээ. Учир нь «Хятад бол олон үндэстэн ястан нийлэн нэгдэж бүрэлдсэн олон хүн ам бүхий улс мөн»⁷ юм гэнээ.

Одоогийн хятадын түүхчдийн энэ мэт өгүүлэх нь хятад үндэстний тухай Чан Кайшийн улиглан хэлж байсан зүйлийг арга буюу санагдуулж байна: «Түүхээс үзвээс хятад үндэстэн бол янз бүрийн овгууд аажмаар хутгалдан нийлэх замаар зохицолдон нэг нэгдмэл цогцос болон

⁵Информационный бюллетень Агентства Синьхуа, 9 октября 1969, № 3305, 36 дугаар тал.

⁶«Лиши яньзю» 1977 № 4, 7 дугаар тал.

⁷Ляонин дасюэ сюэбао. 1977. № 6, 40—42 дугаар тал.

бүрэлдсэн байна. Янз бүрийн эдгээр овог бол өөрсдийн гарал үүслээрээ угтаа нэг л арьстан, нэг л өвөг дээдсийн угсаанаас гарсан салаа мөчрүүд мөн...»⁸

Хятадын түүхчид, археологчид түүхийн баримт сэлт, археологийн олдворуудыг элдвээр гуйвуулан ашиглаж Хятадын хүй нэгдлийн үеийн түүхийг бичихдээ, Хятад бол хүн төрөлхтөн анх үүссэн хамгийн эртний төв, дэлхий дахины соёл иргэншлийн гол голомт байсан мэт дэгэс ойлголтыг уншигчдад төрүүлэхийг чармайж байна.⁹

Тэд түүхийг завхруулахдаа, археологийг онцгой анхаарах болж, түүнийг Хятадын айл хөрш, юуны өмнө БНМАУ, ЗХУ ба бусад улсын эсрэг хандсан их гүрний дээрэнгүй, жанжлах бодлогын үүднээс хортойгоор ашиглаж байна.

Хятадын археологчид «Дундад эзэнт гүрнийг» нүүдэлчин аймаг, «бүдүүлгүүдийн» эсрэг харгалдуулан тавьж, нүүдэлчид бол хэзээнээс Хятадын умард мужуудад оршин суусаар ирсэн «зах хязгаарын ард түмэн» мэт дүрсэлж, хятадын нөлөөг онцгой ач холбогдолтой болгон өргөмжлөхийг бүх хүчээр чармайж байна.

Хятадын археологчдын өгүүлж байгаагаар синантроп* бол хүний хамгийн эртний өвөг мөн. Харин хятадын палеолитийн (хуучин чулуун зэвсгийн) соёл нь Азийн соёлын хамгийн эртний төв, чухам эндээс л соёлын нөлөө Азийн бусад орнуудад түгэж тархсан мэт болж байна.

Хятадын соёл иргэншлийг онцгой байр сууринд тавьж, ер бусын эртний үүсэл гарал, шинж чанартай болгож, умардын «бүдүүлгүүдийн» соёлоос хол давуу талтай гэх зэргээр үзэх явдал одоогийн хятадын эрх баригчдаас айл хөрш орнууд, юуны өмнө БНМАУ-ын газар нутагт өнгөлзөхөд нь «хууль ёсны» эрхийг нь үндэслэж өгөх ёстой ажээ.

Монголын түүхийн хувьд өгүүлэхэд суурин амьдралтай Хятад, Төв Азийн нүүдэлчин аймгууд хоёр бол эрт дээр үеэс угсаа гарал, аж ахуй, соёлоороо өөр өөр, биеэ даасан иргэншлийн хоёр том голомт байсан бөгөөд тус бүр өөртөө онцлог эх сурвалжтай, өвөрмөц түүхтэй болох нь тодорхой билээ.

Төв Азийн өргөн уудам нутаг дэвсгэрт, түүний дотор хээр талын Монгол оронд палеолит, неолитийн (шинэ чулуун зэвсгийн) үеийн өвөрмөц соёл үүсэн хөгжиж байсан бөгөөд энэ нь тэдгээр нутаг дэвсгэрт хүй нэгдлийн үеийн эртний уугуул нутгийн гаралтай хүмүүс анхнаасаа оршин амьдарсаар ирсэн болохыг монгол, зөвлөлтийн археологчдын сүүлийн шинэ нээлтүүд хөдлөшгүй батлан өгөв,

Үүнд палеолитийн доод үеийн дурсгалууд онц ач холбогдолтой болно. Тухайлбал, Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутагт Ярх уулын дэргэдээс олдсон хуучин чулуун зэвсгийн дархны газар, Мандалговь хотоос хойш 60 км-т орших Ёроол говиос, мөн Дорноговь аймгийн Сайншандын орчмоос олдсон эртний хүний бууцыг дурьдаж болно»¹⁰. Эндээс олдсон шөвх гэлбэр, мэсэн зэвсгүүд хийц ба хэлбэрийн хувьд Европ, Өмнөд Ази, Африкийн доод палеолитын хамгийн эртний сонгомол гэлбэр мэсэн зэвсэгтэй тун адил төсөөтэй ажээ.

⁸Чан Кайши «Дундад иргэн улсын хувь заяа», «Лянхэчубаншэ 1945, 2 дугаар тал (хятадаар)

⁹«Хятадын түүхийн тойм» I богь, редактор Го Мо:ко Бээжин. 1977. (хятад хэлээр)

*Синантрон (син-антроп)-хятад хүн, Бээжин хүн (—Хятадад оршиж байсан хамгийн эртний хун Бээжингийн орчмоос олдсоныг ийн нэрлэнэ.

¹⁰Дорж. Нижний палеолит Монголии и его место в древне-каменном веке Центральной Азии. III. международный конгресс монголоведов. Т. III, УБ., 156—160 дугаар тал.

Төв Азид анх олдсон эдгээр багаж хэрэгсэл сайн хийцтэйгээрээ онцлог болохоос гадна Монголын нутаг дэвсгэрт анхлан хүн бий болж оршин суусан асуудалтай шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл эдгээр баримт нь Монгол оронд одоогоос 400-гаад мянган жилийн өмнө хүн лав оршин амьдрах болсныг тодорхой гэрчилж байна.

Нөгөө талаар Умард ба Дундад Азийн эртний соёлыг судлагч зөвлөлтийн нэрт археологч академич А. П. Окладниковын тэмдэглэснээр «тоог ярихгүй гэхэд, ашелийн (палеолитийн хамгийн эртний) загварт багаж хэрэгслийн хэлбэрүүдийг онцлогоор нь ангилсантай зэрэгцүүлж үзвэл, олдворын энэ газар (Ярхыг хэлж байна-ред) Хятад дахь Дин-цунь мэтийн дурсгалуудтай зүйрлүүлэшгүй ...Динцунь бол өвөрмөц үзэгдэл юм ...Энд өрнөдийн маягийн гэлбэр мэсэн зэвсэг, үзүүр мэсэн зэвсэг байхгүй»¹¹. Ийм болохоор Азийн доод палеолитийн үеийн хүрээ хязгаар одоо Жоукоудяниас (Бээжингийн ойролцоох газар) умар зүг тийш нилээд гүн тэлэгдэж ирж байна.

Монголын неолитийн үеийн тухайд гэвэл, Дорнод Монголын Тамсаг булгийн орчинд нээсэн неолитийн соёлын ач холбогдлыг цохон тэмдэглэвэл зохих бөгөөд энэ нь Төв Азид үүссэн нэн эртний газар тариалан мал аж ахуйн төвүүдийн нэг байсныг гэрчилж байгаа юм.¹²

Ийнхүү зөвлөлт, монголын археологчдын сүүлийн үеийн олдвор нээлтээс үзвэл, Төв Ази, түүний дотор Монгол орон нь Хятадын Шар мөрний дунд урсгалаар үүссэн соёлын төвийн алс бөглүү хязгаар төдийхөн байсан нь огт биш, харин мөнхүү Шар мөрний усан савын яньшао хэмээх газрын эртний неолитийн үеийн соёлтой бүхэлдээ нэгэн зэрэг үүссэн, биеэ даасан неолитийн соёлын нэг төв байсныг онцлон тэмдэглэвэл зохино. (Үргэлжлэлийг дараагийн дугаараас үзнэ үү)

МАОИСТСКАЯ ФАЛЬСИФИКАЦИЯ ИСТОРИИ МНР И ИСТОРИЧЕСКАЯ ПРАВДА

(Резюме)

**Ш. Бира
Н. Ишжамц
Ш. Сандаг**

Важное место в обосновании гегемонистской, экспансионистской политики маоистов занимает фальсификация истории соседних с Китаем стран и национальных меньшинств, проживающих в Китае. В последнее время особенно активизируются усилия Пекина, направленные на изучение различных периодов истории монгольского народа в угоду великодержавной шовинистической политике китайского руководства. Так, например, в июле 1980 года в Хайларе было проведено совещание китайс-

¹¹ А. П.. Окладников. К истории первоначального освоения человеком Центральной Азии.— «Центральная Азия и Тибет», «История и культура востока Азии». Новосибирск. 1972. 21 дүгээр тал.

¹²Д. Дорж. Тамсагбулагская культура и ее место в древнейшей истории Центральной Азии.—«Роль кочевых народов в цивилизации Центральной Азика» УБ., 1974.

ких монголоведов, а в октябре того же года в городе Нанкине образовано Общество по исследованию истории династии Юань.

В 1980 г. в Улан-Баторе на русском и английском языках вышла брошюра «Маоистская фальсификация истории МНР и историческая правда», написанная монгольскими историками-Ш. Бира, Н. Ишжамцем и Ш. Сандагом.

Редакция начинает публикацию монгольского текста брошюры на страницах журнала. Первая часть называется «Китаецентризм и древняя история Монголии». Продолжение будет опубликовано в последующих номерах.